



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 03. 24 № 3/542
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Монгол Улсын Их Сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Монгол Улсын Их Сургуулийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Их Сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:

Санхүүгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор

Ц.Наранчимэг

Утас: 261663

Аудитын менежер: **Я.Самбууням**

Утас: 261885

Шинжээч: **Б.Баярмаа**

Утас: 260512

Төрийн аудитын байгууллагын хаяг:
Үндэсний Аудитын Газар

Байршил:
Чингэлтэй дүүрэг

Цахим хуудас:
www.audit.mn

ГАРЧИГ

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2017 оны 3 дугаар сар

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	4
3	Байгууллагын хууль, эрх зүйн орчин	4
4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	5
5	Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн	5
6	Материаллаг байдлын түвшин	6
7	Дотоод хяналт	6
8	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	6
9	Шилэн дансны мэдээлэл	6
10	Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар	7
11	Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар	7
12	Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар	7
13	Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар	8
14	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
15	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	8
16	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	8
17	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
18	Зөрчилгүй санал дүгнэлт	9
19	Менежментийн захидал	11
20	Аудитлагдсан санхүүгийн тайлан	13
21	Санхүүгийн тайлангийн тодруулга	19
22	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	23

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэл тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Монгол улсын их сургуулийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт оршино.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Монгол улсын их сургуулийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 2 дугаар сарын 3-аас 3-р сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн, “Акпар-Аудит” компанийн ахлах аудитор Ж.Амаржаргалаар удирдуулсан аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Монгол улсын их сургууль нь 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 24-нд “Акпар-Аудит” компанид ирүүлсэн байна.

“Акпар-Аудит” компанижилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын ажлыг 2017 оны 2 дугаар сарын 14-ээс 2017 оны 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 15-нд Үндэсний аудитын газарт хүргүүлнэ.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Монгол улсын их сургууль нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Боловсролын тухай”, “Дээд боловсролын тухай”, “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Төрийн аудитын тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Монгол Улсын Их Сургууль (МУИС) нь бүрэлдэхүүн 5 сургууль, орон нутаг дахь харьяаллын 2 сургууль, үндэсний статустай 3 хүрээлэн, судалгааны бусад нэгжүүдтэй, бакалавр, магистр, докторын түвшний боловсон хүчин бэлтгэх үйл ажиллагаа явуулж байна.

1990-ээд оноос хойшхи хугацаанд дээд боловсролыг шаталсан сургалтын тогтолцоонд шилжүүлэх, кредит системийг нэвтрүүлэх, их сургуулийг санхүүгийн хувьд өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчимд нийцүүлэн өөрчлөх, боловсролын агуулга, стандартыг өрнөдийн өндөр хөгжилтэй орнуудын их дээд сургуулиудын жишигт ойртуулахад чиглэсэн өөрчлөлтүүдийг хийж ирсэн байна.

2014-2015 оны хичээлийн жилээс шинэ бүтэц, зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд МУИС-ийн 2020 он хүртэлх хөгжлийн Стратеги төлөвлөгөөг шинэчлэн баталсан.

МУИС-ийг сургалтад суурилсан их сургуулиас тогтвортой хөгжлийн үзэл баримтлал бүхий академик мэдлэгийг нийгэм-эдийн засгийн эргэлтэд оруулдаг, хөгжил дэвшилд хувь нэмэрээ оруулдаг судалгааны их сургууль болгон өөрчлөх зорилт тавин ажиллаж байна.

Монгол улсын их сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Монгол улсын их сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 64-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан Монгол улсын их сургуулийн захирлын 2015 оны 6-р сарын 9-ний А/165 тоот тушаалаар баталж, баталсан өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон холбогдох стандартуудтай нийцүүлэн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн “Power soft” программыг ашиглаж байна.

Монгол улсын их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” гэсэн үнэлгээ гарсан тул мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэж үзлээ. /ТАБ-СТА-В-2/

Монгол улсын их сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу гаргасан байна.

Материаллаг байдлын түвшин

Материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үед тэвчиж болох хамгийн бага дүнгээр буюу нийт зардлын 0.2 хувиар авсан. Гүйцэтгэлийн үе шатанд мөн нийт зардлын 0,2 хувь буюу 76,350,421.51 төгрөгөөр тооцож тогтоосон.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Монгол улсын их сургуулийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад анхаарал татсан зүйл ажиглагдаагүй.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийн зардлыг төрөл зүйлээр хуваариалан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Монгол улсын их сургуулийн 2016 оны нийт орлого, зардлын гүйцэтгэл дараах байдалтай бөгөөд үүнээс үзэхэд орлогын төлөвлөгөөг 2,83 хувиар давуулан биелүүлж, харин үйл ажиллагааны зардлыг 8,35 хувиар хэмнэсэн байна.

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого	45,822,766,530.00	47,119,040,925.12	1,296,274,395.12	102.83
Үйл ажиллагааны нийт зардал	39,259,801,000.00	35,980,791,295.35	(3,279,009,704.7)	91.65

Шилэн дансны мэдээлэл

Монгол улсын их сургуулийн шилэн дансны цахим хуудас нь дотроо:

- Хууль, журам,
- Төсвийн гүйцэтгэл,
- Хөрөнгө оруулалт,
- Тендер ба худалдан авалт,
- Байгууллага гэсэн 5 хэсэгтэй байна.

Шилэн дансанд цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээнүүд болон 2016 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны төсөв, аудитын дүгнэлт, аудитлагдсан санхүүгийн тайлан, хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл, хандив, тусламж

түүний зарцуулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендер шалгаруулалт явуулах журам зэргийг байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 64 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горимуудыг гүйцэтгэсэн.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Дээрхи 64 эрсдэлээс 5 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг 2017 онд багтаан арилгах талаар зөвлөмж бичиж хүргүүлсэн.

Илрүүлсэн зөрчлүүдийн талаар “Асуудлын бүртгэл”-д тодорхой тусгасан болно.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Монгол улсын их сургуулийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин хөлсний тооцоо зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Тус сургуульд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, ашиглах хугацаа дуусч, эвдэрч муудсанаас цаашид ашиглагдах боломжгүй болсон анхны өртгөөр 745,298,842.02 төгрөгийн үндсэн хөрөнгө, 30,044,340.00 төгрөгийн биет бус хөрөнгө, 132,147,228.53 төгрөгийн эргэлтийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Шийдвэрлэсэн: Дээрхи ашиглалтгүй болсон хөрөнгийг Удирдах зөвлөлийн хуралд оруулан тус зөвлөлийн 2016 оны 02 тоот тогтоолоор актлах шийдвэр гаргасан боловч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэр гараагүй тул акталж, данснаас хасаагүй байна. 2017 оны эхний хагас жилд багтаан шийдвэр гаргуулж актлах зөвлөмж өгсөн.

2. Бизнесийн сургуульд хариуцах эзэд нь тодорхойгүй, олон жил дамжин, хөөн хэлэлцэх хуулийн хугацаа нь дууссан 64,356,586.87 төгрөгийн, Төвлөрсөн сан болон Өвөр Зайсан сургалт судалгааны төвд үхсэн малтай холбоотой төлөгдөх эсэх нь эргэлзээтэй 3,094,000.00 төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Эргэлзээтэй авлагын нийт дүн нь 67,450,586.87 төгрөг.

Шийдвэрлэсэн: Олон жил дамжсан, төлөгдөхгүй байгаа авлага бүрээр нарийвчилсан судалгаа гаргаж, хариуцах эзэн, нотлох баримтыг нь тодорхой болгон хуулийн байгууллагад шилжүүлж, 2017 онд багтаан барагдуулах арга хэмжээ авах.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Илэрсэн алдаа, зөрчлүүдийн талаар тодорхой зөвлөмж бичиж хүргүүлсэн тул залруулан бичилт хийх шаардлагагүй гэж үзлээ.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

2016 онд Үндэсний аудитын газраас оюутнуудаас авч буй суурь төлбөрийг зөрчилд тооцож, уг зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн байна.

Уг албан шаардлагыг МУИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлаар хэлэлцээд, Удирдах зөвлөлийн дэд дарга Д.Эрдэнэчимэгээр ахлуулсан ажлын хэсэг байгуулж, Үндэсний аудитын газрын албан шаардлагад дурьдсан “суурь төлбөр”-ийн үндэслэлийн талаар санал боловсруулж, Үндэсний аудитын газрын холбогдох албатай зөвшилцөхийг даалгасан байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд МУИС-ийн Оюутны холбооны тэргүүнийг оруулсан байна.

Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын шийдвэрээр Удирдах зөвлөлийн дарга болон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсны зэрэгцээ сургуулийн захирлыг мөн өөрчилсөн байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талааргэсэн хэсэгт дурьдсан зөрчлийг арилгасан эсэхийг шалгах.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Монгол улсын их сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 974,940,997.42 төгрөгийн зөрчил илэрсэнийг арилгах талаар зөвлөмж бичиж, хүргүүлсэн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Монгол улсын их сургуулийн 2015 оны санхүүгийн тайланд “Акпар-Аудит” компани аудит хийж 4 зөвлөмж өгсөн ба биелэлт нь дараах байдалтай байна.

Д/д	Илэрсэн зөрчил	Өгсөн зөвлөмж	Биелэлт
1	Бизнесийн сургуульд хариуцах эзэд нь тодорхойгүй, олон жил дамжин, хөөн хэлэлцэх хуулийн хугацаа нь дууссан 67,594,086.87 төгрөгийн авлага бүртгэлтэй байна	Олон жил дамжсан авлагын төлөгдөхгүй байгаа шалтгааныг нь авлага бүрээр судалж, Бизнесийн сургуулийн захирлын зөвлөл, болон МУИС-ийн Удирдах зөвлөлийн хуралд оруулан танилцуулж, эргэн төлөгдөх боломжгүй гэж үзсэн авлагыг Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр данснаас хасах.	Авлага бүрийг нарийвчлан судалж, зарим авлагын эзэн холбогдогчийг тодорхой болгосны үр дүнд 3,237.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан. Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр үлдсэн авлагыг хуулийн байгууллагад шилжүүлэх шийдвэр гаргасан.

2	Төвлөрсөн сан болон Өвөр Зайсан сургалт судалгааны төвийн дансанд 3,094,000.00 төгрөгийн үнэтэй 1 морь, 66 толгой хонь бүртгэлтэй байна. Эдгээр морь, мал нь аль эрт үхэж, үрэгдсэн боловч бүртгэлээс хасаагүй байна.	Байхгүй болсон малыг МУИС-ийн Удирдах зөвлөлийн хуралд оруулан танилцуулж, данснаас хасах.	Удирдах зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж, үхсэн малыг авлагын бүртгэлд шилжүүлэн бүртгэж, холбогдох материалыг шүүхэд шилжүүлэх шийдвэр гаргасан.
3	Тус сургуулийн ашиглаж байгаа “Power soft” санхүүгийн программ хангамж нь Сангийн яамнаас албан ёсоор зөвшөөрөл аваагүй байна.	Сангийн яамнаас гаргасан дээрхи журмын дагуу албан ёсоор зөвшөөрөл авахыг уг программ хангамжийг нийлүүлэгч талаас шаардах, зөвшөөрөл авах боломжгүй бол сангийн яамны зөвшөөрөлтэй программ хангамжуудаас шинээр худалдаж авах.	Удирдах зөвлөлийн хурлаар шинээр программ худалдаж авах шийдвэр гарган олон нийтийн хэрэгсэлээр 4 удаа тендер зарласан ч шаардлага хангасан программ ирээгүй тул 2017 онд дахин зарлахаар болсон.
4	Тус сургууль нь бие даан орлого төвлөрүүлж, зарцуулах эрхтэй олон салбар нэгжтэй боловч тэдний үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналт шалгалтын нэгжгүй байна.	“Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 7.2 болон 8.2.1-р заалт болон дээрхи тогтоолоор баталсан нийтлэг журмыг үндэслэн төв аппарат болон харьяа байгууллага, аж ахуйн нэгжид дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг боловсруулан, мөрдөж ажиллах.	2016 оны 9-р сараас МУИС-ийн Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний албаны мониторингийн ажилтаны ажил үүргийн хуваарьт оруулан дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж эхэлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол улсын их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Монгол улсын их сургууль

2016ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ № 1

Хуудас

Асуудал 1

Хөрөнгийн талаар

12

Асуудал 2

Авлагын талаар

12

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ № 2

2017 оны 3 дугаар сар

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Монгол улсын их сургуулийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийгөглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Монгол улсын их сургуулийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1

Ашиглалтгүй болсон хөрөнгийг актлах	Тэргүүлэх ач холбогдол № 1
Бодит байдал:	Зөвлөмж:
Тус сургуульд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, ашиглах хугацаа дуусч, эвдэрч муудсанаас цаашид ашиглагдах боломжгүй болсон анхны өртгөөр 745,298,842.02 төгрөгийн үндсэн хөрөнгө, 30,044,340.00 төгрөгийн биет бус хөрөнгө, 132,147,228.53 төгрөгийн эргэлтийн хөрөнгө бүртгэлтэй байна.	Ашиглагдах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг зохих журмын дагуу 2017 оны эхний хагас жилд багтаан актлуулах арга хэмжээ авах.
Эрсдэлүүд:	Үйлчлүүлэгчийн хариу:
Ашиглах боломжгүй хөрөнгийг бүртгэл, дансанд тусгасанаар хөрөнгийн үлдэгдэл илүү илэрхийлэгдэж, нийт хөрөнгийн хэмжээ, нөөцийг тооцоолоход сөрөг нөлөө үзүүлнэ.	Дээрхи ашиглалтгүй болсон хөрөнгийг Удирдах зөвлөлийн хуралд оруулан тус зөвлөлийн 2016 оны 02 тоот тогтоолоор актлах шийдвэр гаргасан. Зохих журмын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулан актлах зөвшөөрөл авна.

Асуудал 2

Найдваргүй авлагыг хаах	Тэргүүлэх ач холбогдол № 1
Бодит байдал:	Зөвлөмж:
Бизнесийн сургуульд хариуцах эзэд нь тодорхойгүй, олон жил дамжин, хөөн хэлэлцэх хуулийн хугацаа нь дууссан 64,356,586.87 төгрөгийн, Төвлөрсөн сан болон Өвөр Зайсан сургалт судалгааны төвд үхсэн малтай холбоотой төлөгдөх эсэх нь эргэлзээтэй 3,094,000.00 төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Эргэлзээтэй авлагын нийт дүн нь 67,450,586.87 төгрөг байна.	Олон жил дамжсан, төлөгдөхгүй байгаа авлага бүрээр нарийвчилсан судлагаа гаргаж, хариуцах эзэн, нотлох баримтыг нь тодорхой болгон хуулийн байгууллагад шилжүүлж, 2017 онд багтаан барагдуулах арга хэмжээ авах.
Эрсдэлүүд:	Үйлчлүүлэгчийн хариу:
Найдваргүй авлага хөрөнгө биш учир байгууллагын нийт хөрөнгийг хий өсгөж харуулдаг ба яваандаа алдагдал болдог.	Олон жил дамжсан авлагын нэхэмжлэгчээр сургуулийн хуулийн зөвлөх Б.Энхтайваныг томилж, 2017 онд багтаан барагдуулах үүрэг өгч ажиллаж байна.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	21,238,576,742.06	21,673,512,194.94
Кассанд байгаа бэлэн мөнгө	9,083,704.98	6,721,731.00
Жижиг мөнгөн сан		
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	18,079,583,980.66	16,834,930,834.58
Банкинд байгаа бэлэн мөнгө /гадаад валют/	3,149,909,056.42	4,831,859,629.36
Тусгай зориулалтын сангийн харилцах		
Замд яваа мөнгөн хөрөнгө		
АВЛАГА	1,903,353,782.44	2,243,252,646.91
Төлбөртэй үйлчилгээний авлага	343,292,448.34	710,443,564.00
Бусад авлага	1,560,061,334.10	1,532,809,082.91
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	0.00	0.00
Урьдчилгаа тооцоо		
Урьдчилж гарсан зардал		
БАРАА МАТЕРИАЛ	1,863,057,507.44	2,235,411,518.95
Түүхий эд материал	2,519,849.76	2,333,752.27
Дуусаагүй үйлдвэрлэл		
Бэлэн бүтээгдэхүүн		
Хангамжийн материал	1,857,443,657.68	2,233,077,766.68
Мал, амьтад	3,094,000.00	
Бусад		
НӨӨЦИЙН БАРАА		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,004,988,031.94	26,152,176,360.80
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	42,535,545,492.85	50,570,054,319.09
Биет хөрөнгө	42,430,159,152.50	50,439,259,096.18
Барилга, байгууламж	56,104,967,575.72	56,760,508,185.72
Хуримтлагдсан элэгдэл	(29,197,683,487.66)	(30,186,115,544.48)
Авто-тээврийн хэрэгсэл	369,408,436.00	369,408,436.00
Хуримтлагдсан элэгдэл	(316,311,015.39)	(340,367,035.11)
Машин тоног төхөөрөмж	11,844,481,152.00	13,000,786,862.68
Хуримтлагдсан элэгдэл	(6,683,259,209.71)	(8,150,988,812.75)
Тавилга, аж ахуйн эд хогшил	5,054,417,546.29	5,333,301,630.29
Хуримтлагдсан элэгдэл	(2,949,497,520.19)	(3,310,565,223.36)
Түүх соёлын дурсгалт зүйлс		
Хуримтлагдсан элэгдэл		
Номын фонд	2,219,144,968.80	2,496,687,298.50
Хуримтлагдсан элэгдэл		
Бусад үндсэн хөрөнгө	292,080,405.00	308,946,405.00
Хуримтлагдсан элэгдэл	(174,882,107.36)	(195,240,780.50)
Дуусаагүй барилга, байгууламж	5,867,292,409.00	14,352,897,674.19
Биет бус хөрөнгө	105,386,340.35	130,795,222.91

Программ хангамж	187,860,700.52	237,855,070.52
Хуримтлагдсан элэгдэл	(82,474,360.17)	(107,059,847.61)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	100,000,000.00	100,000,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	42,635,545,492.85	50,670,054,319.09
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	67,640,533,524.79	76,822,230,679.89
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Өглөг	524,366,892.36	182,691,642.43
Ажиллагсадтай холбоотой өглөг	116,582,733.89	140,369,256.36
Бараа үйлчилгээтэй холбоотой өглөг	294,726,115.89	41,112,481.39
НДШ-ийн өглөг	422,227.65	762,904.68
Татаас, санхүүжилтийн өглөг		
Бусад өглөг	112,635,814.93	447,000.00
Урьдчилж орсон орлого	5,927,461,425.01	5,143,408,173.76
Урьдчилгаа- Төсвийн татаас	7,268,000.00	7,268,000.00
Бусад урьдчилж орсон орлого	5,920,193,425.01	5,136,140,173.76
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	6,451,828,317.37	5,326,099,816.19
Урт хугацаат зээл		
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	0.00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	6,451,828,317.37	5,326,099,816.19
ЭЗДИЙН ӨМЧ		
Засгийн газрын хувь оролцоо	19,882,266,188.17	19,882,266,188.17
Хуримтлагдсан үр дүн	23,523,106,676.77	33,830,532,333.05
Өмнөх үеийн үр дүн	17,053,008,309.58	23,523,106,676.77
Тайлант үеийн үр дүн	6,470,098,367.19	10,307,425,656.28
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,783,332,342.48	17,783,332,342.48
ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	61,188,705,207.42	71,496,130,863.70
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	67,640,533,524.79	76,822,230,679.89

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Улсын төсвөөс	3,689,100,548.52	5,008,943,490.79
Урсгал	987,006,878.62	1,079,256,296.94
Хөрөнгийн	1,329,077,645.90	789,540,297.85
Орон нутгийн төсвөөс	144,729,324.00	228,149,636.00
Бусад төсөвт байгууллагаас		1,739,316,160.00
Бусад тусгай зориулалтын сангаас	1,228,286,700.00	1,172,681,100.00
Тусламжийн орлого	358,372,654.10	545,009,682.31
Бусад байгууллагаас	358,372,654.10	545,009,682.31
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	37,479,010,698.73	42,042,057,349.16
Үндсэн үйл ажиллагааны орлого	31,488,128,662.95	36,320,693,758.92
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	5,718,634,096.25	5,322,457,235.05
Торгууль төлбөрийн орлого	272,247,939.53	398,906,355.19
Үнэ төөбөргүй хүлээн авсан орлого		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	41,526,483,901.35	47,596,010,522.26
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	23,759,093,245.68	25,635,710,610.96
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	21,409,208,561.58	23,082,082,306.66
Цалин	21,409,208,561.58	23,082,082,306.66
Бусад нэмэгдлүүд		
Нийгмийн даатгал	2,349,884,684.10	2,553,628,304.30
Нийгмийн даатгалын шимтгэл	2,349,884,684.10	2,553,628,304.30
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	11,386,413,446.18	12,539,500,145.55
Тогтмол зардал	987,006,878.62	1,079,256,296.89
Гэрэл цахилгааны зардал	471,222,662.92	549,808,403.00
Түлш, халаалтын зардал	367,790,294.70	386,467,372.33
Цэвэр, бохир усны зардал	147,993,921.00	142,980,521.56
Үйл ажиллагааны зардал	3,912,079.98	3,045,066.77
Хоолны зардал		
Эмийн зардал	3,912,079.98	3,045,066.77
Бусад бараа, үйлчилгээний зардал	10,395,494,487.58	11,457,198,781.89
Бичиг хэргийн материал	107,182,501.89	80,211,341.59
Тээвэр, шатахууны зардал	29,516,824.17	29,800,409.72
Шуудан холбооны зардал	231,142,482.56	224,736,239.43
Дотоод албан томилолтын зардал	23,396,716.76	15,469,393.17
Гадаад албан томилолтын зардал	57,350,283.65	54,332,056.00
Ном, хэвлэлийн зардал	34,309,456.52	67,949,268.57
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,211,217,299.70	1,303,545,122.86
Сургалт семинарын зардал	419,273,338.47	626,547,371.10
Эрдэм шинжилгээний ажлын зардал	2,606,942,484.82	3,292,698,777.90
Жижиг эд хогшил худалдан авах зардал	315,965,091.58	313,314,068.45

Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	12,807,614.61	2,945,851.88
Төлбөр, хураамж, жижиг татварууд	266,425,821.35	112,653,699.34
Харуул хамгаалалтын зардал	300,828,000.00	299,175,900.00
Банкны үйлчилгээний хураамж	13,783,923.59	6,711,169.28
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил гүйлгээ		
Урсгал засварын зардал	798,614,200.76	777,306,865.21
Биеийн тамирын уралдаан тэмцээний зардал	64,875,360.00	92,604,864.95
Гадаад зочины зардал	119,743,854.05	198,305,429.83
Бусад зардал	182,519,972.06	327,042,823.91
Байрны түрээсийн зардал		
Элэгдлийн зардал	2,793,405,033.46	2,886,229,543.33
Хөтөлбөр арга хэмжээний зардал	207,237,385.72	291,301,808.21
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	286,015,517.60	354,637,792.28
Бусад зардал	312,941,324.26	99,678,984.88
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	35,145,506,691.86	38,175,210,756.51
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	6,380,977,209.49	9,420,799,765.75
<i>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</i>		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (бодит)	259,466,080.72	982,269,547.30
Үндсэн хөрөнгө худалдсаны олз		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	259,466,080.72	982,269,547.30
<i>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</i>		
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз (бодит)	110,271,292.66	95,643,656.77
Бараа материал худалдсаны гарз		
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	60,073,630.36	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	170,344,923.02	95,643,656.77
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	6,470,098,367.19	10,307,425,656.28

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Татаас, санхүүжилтийн орлого	4,846,582,465.70	5,566,089,991.70
Улсын төсвөөс	3,517,504,819.80	4,906,104,693.85
Урсгал	286,380,400.00	1,100,000,000.00
Хөрөнгийн	1,329,077,645.90	659,985,297.85
Орон нутгийн төсвөөс	297,390,110.00	329,086,236.00
Бусад тусгай зориулалтын сангаас	1,604,656,663.90	2,817,033,160.00
Тусламжийн орлого	0.00	0.00
Бусад байгууллагаас		
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	38,885,017,366.31	42,212,936,231.27
Үндсэн үйл ажиллагааны орлого	32,259,914,825.68	35,057,882,928.74
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	6,625,102,540.63	7,155,053,302.53
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	42,402,522,186.11	47,119,040,925.12
Ажиллагсадтай холбогдсон зардал	23,793,999,752.49	25,614,600,040.66
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	21,427,966,394.79	23,012,404,309.01
Цалин	21,427,966,394.79	23,012,404,309.01
Бусад нэмэгдлүүд		
Нийгмийн хамгааллын шимтгэл	2,366,033,357.70	2,602,195,731.65
Нийгмийн даатгалын шимтгэл	2,366,033,357.70	2,602,195,731.65
Бараа үйлчилгээний урсгал зардал	9,541,275,102.44	10,366,191,254.69
Бичиг хэргийн зардал	44,854,710.00	37,537,214.00
Гэрэл цахилгааны зардал	471,222,662.92	549,808,403.00
Түлш, халаалтын зардал	375,776,467.70	395,651,702.54
Цэвэр, бохир усны зардал	147,993,921.00	141,692,466.35
Байрны түрээсийн зардал		
Тээвэр, шатахууны зардал	25,714,110.00	26,349,005.00
Шуудан холбооны зардал	221,848,986.01	224,459,893.20
Дотоод албан томилолтын зардал	33,300,224.00	17,627,578.40
Гадаад албан томилолтын зардал		
Ном, хэвлэлийн зардал	33,444,260.00	25,434,554.00
Аж ахуйн материалын зардал	466,068,874.55	439,277,806.17
Урсгал засварын зардал	808,318,235.04	785,630,395.00
Сургалт семинарын зардал	505,613,307.65	631,682,796.40
Төлбөр, хураамж, жижиг татварууд	438,340,933.66	237,573,495.13
Харуул хамгаалалтын зардал	300,828,000.00	299,175,900.00
Банкны үйлчилгээний хураамж		
Хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны зардал	22,768,193.47	41,995,826.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,206,777,419.79	1,199,835,618.17
Эрдэм шинжилгээний ажлын зардал	2,925,351,919.80	3,768,159,459.92
Оюутны үйлчилгээний зардал	412,670,350.00	473,894,178.00
Гадаад зочины зардал	193,786,936.96	257,171,914.09
Биеийн тамирын уралдаан тэмцээний зардал	62,332,511.00	86,813,824.00

Салбарын төвлөрсөн арга хэмжээний зардал	238,619,609.92	332,134,001.00
Оюутны тэтгэлэг	100,079,900.00	100,936,600.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	236,823,632.00	293,348,624.32
Улаанбаатар сургуульд олгосон	268,739,936.97	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	33,335,274,854.93	35,980,791,295.35
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	9,067,247,331.18	11,138,249,629.77
Хөрөнгийн орлого /ХО-ийн санхүүжилт/ Үндсэн хөрөнгө борлуулсны орлого Бусад хөрөнгийн борлуулалтын орлого		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	3,111,767,369.70	2,216,423,613.85
Их засварын зардал	5,495,226,482.90	8,486,890,563.04
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)	8,606,993,852.60	10,703,314,176.89
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)	(8,606,993,852.6)	(10,703,314,176.9)
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)	460,253,478.58	434,935,452.88
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,778,323,263.48	21,238,576,742.06
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,238,576,742.06	21,673,512,194.94

СТ-4А

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний	Хуримтлагдсан	Дүн
2014 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	21,873,016,406.29	18,444,032,693.48	16,779,175,198.07	57,096,224,297.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,990,750,218.12)		273,833,111.51	(1,716,917,106.61)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		(660,700,351.00)		(660,700,351.00)
Тайлант үеийн үр дүн			6,470,098,367.19	6,470,098,367.19
2015 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	19,882,266,188.17	17,783,332,342.48	23,523,106,676.77	61,188,705,207.42
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Тайлант үеийн үр дүн			10,307,425,656.28	10,307,425,656.28
2016 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	19,882,266,188.17	17,783,332,342.48	33,830,532,333.05	71,496,130,863.70

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТОДРУУЛГА

Санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө болон түүний эх үүсвэрийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө

Тус сургууль нь олон салбартай тул Төрийн сан болон арилжааны банкуудад төгрөгийн болон валютын харилцах, хадгаламжийн дансуудтай байна.

Үзүүлэлт	2015 он	2016 он
Бэлэн мөнгө		
Кассанд байгаа бэлэн мөнгө	9,083,704.98	6,721,731.00
Бэлэн мөнгөний дүн	9,083,704.98	6,721,731.00
Банкин дахь мөнгөн хөрөнгө		
Төгрөгийн харилцахын үлдэгдэл	18,079,583,980.66	16,834,930,834.58
Гадаад валютын харилцахын үлдэгдэл	3,149,909,056.42	4,831,859,629.36
Банкин дахь мөнгөн хөрөнгийн дүн	21,229,493,037.08	21,666,790,463.94
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	21,238,576,742.06	21,673,512,194.94

Дансны авлага

Сургалтын төлбөрийн авлага болон байгууллага, хүмүүсээс авах авлага илүү төлсөн ХХОАТ, нийгмийн даатгалын шимтгэлийг дансны авлагаар бүртгэсэн байна.

Үзүүлэлт	2015 он	2016 он
Тогтмол зардлын санхүүжилтийн үлдэгдэл	887,006,929.73	866,263,226.67
Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэл	4,995,069.25	2,716,634.76
Түрээсийн авлага		
Илүү төлсөн татвар	1,824,317.01	7,541,750.39
Байгууллагаас авах авлага	393,035,771.82	355,148,317.65
Хүмүүстэй хийх тооцоо	267,187,896.85	301,139,153.44
Бусад	6,011,349.44	
Сургалтын төлбөрийн авлага	343,292,448.34	710,443,564.00
Дүн	1,903,353,782.44	2,243,252,646.91

Сургалтын төлбөрийн задаргаа

Үзүүлэлт	2015 он	2016 он
Бакалаврын сургалт	35,600,000.00	97,779,134.00
Магистрын сургалт	4,552,630.00	55,907,640.00
Гадаад оюутаны сургалт	188,418.34	1,963,390.00
СТС	300,589,400.00	548,841,400.00
МСҮТ сургалт	2,362,000.00	5,952,000.00
Дүн	343,292,448.34	710,443,564.00

Бараа материал

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор бэлтгэсэн бичиг хэрэг, сэлбэг хэрэгсэл, хангамжийн материал зэргийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Бараа материалын үлдэгдэл дараах байдалтай байна.

Үзүүлэлт	2015 он	2016 он
Шатах тослох материал	304,000.00	141,400.00
Сэлбэг хэрэгсэл	193,173,351.55	128,735,556.67
Эм, боох материал	2,669,549.76	2,483,452.27
Барилгын материал	21,497,418.01	27,805,490.20
Хүнсний материал	20,473,246.99	2,530,837.36
Бичиг хэрэг	451,762,055.78	407,156,444.80
Хангамжийн материал	1,167,602,187.45	1,664,698,515.75
Түүхий эд материал	2,481,697.90	1,859,821.90
Мал, амьтад	3,094,000.00	
Бараа, үйлчилгээний зардлын дүн	1,863,057,507.44	2,235,411,518.95

Үндсэн хөрөнгө

Батлагдсан төсвийн хөрөнгөөр худалдаж авсан болон тусламж хандиваар ирсэн хөрөнгөөр үндсэн хөрөнгийн хэмжээ нь нэмэгдсэн ба ангилал хооронд шилжүүлсэн хөрөнгөөр багассан байна. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна.

Хөрөнгийн ангилал	Оны эхний үлдэгдэл	Өөрчлөлт		Оны эцсийн үлдэгдэл
		нэмэгдсэн	Хасагдсан	
Барилга	56,104,967,575.72	655,540,610.00		56,760,508,185.72
байгууламж				
Тээврийн хэрэгсэл	369,408,436.00			369,408,436.00
Сургалтын тоног төхөөрөмж	11,844,481,152.00	1,667,130,811.01	510,825,100.33	13,000,786,862.68
Тавилга эд хогшил	5,054,417,506.29	344,935,776.56	66,051,692.56	5,333,301,590.29
Номын фонд	2,219,144,968.80	278,269,411.64	727,081.94	2,496,687,298.50
Бусад үндсэн хөрөнгө	292,080,405.00	33,732,000.00	16,866,000.00	308,946,405.00
Дуусаагүй барилга	5,867,292,409.00	8,485,605,265.19		14,352,897,674.19
Программ хангамж	187,860,700.52	49,994,370.00		237,855,070.52
Үндсэн хөрөнгийн дүн	81,939,653,153.33	11,515,208,244.40	594,469,874.83	92,860,391,522.90

Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг хөрөнгийн ашиглах хугацааг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулсан байна.

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэл дараах байдалтай байна.

Хөрөнгийн ангилал	Оны эхний үлдэгдэл	Өөрчлөлт		Оны эцсийн үлдэгдэл
		нэмэгдсэн	Хасагдсан	
Барилга байгууламж	29,197,683,487.66	988,432,056.82		30,186,115,544.48
Тээврийн хэрэгсэл	316,311,015.39	24,056,019.72		340,367,035.11
Сургалтын тоног төхөөрөмж	6,683,259,209.71	1,467,729,603.04		8,150,988,812.75
Тавилга эд хогшил	2,949,497,480.19	361,067,703.17		3,310,565,183.36
Номын фонд				
Бусад үндсэн хөрөнгө	174,882,107.36	20,358,673.14		195,240,780.50
Дуусаагүй барилга				
Программ хангамж	82,474,360.17	24,585,487.44		107,059,847.61
Үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн	39,404,107,660.48	2,886,229,543.33		42,290,337,203.81
Үлдэгдэл өртөг	42,535,545,492.85			50,570,054,319.09

Урт хугацаат хөрөнгө оруулалт

2001 онд “Хөвсгөл усан зам” компаниас худалдан авсан хувьцааг бүртгэсэн байна.

Үзүүлэлт	2015 он	2016 он
“Хөвсгөл усан зам” компанийн хувьцаа	100 000 000,00	100 000 000,00
Бараа, үйлчилгээний зардлын дүн	100 000 000,00	100 000 000,00

Дансны өглөг

Дансны өглөгийн дийлэнх нь худалдагдсан газрын урьдчилгаа болон цахилгаан, дулааны төлбөр, цалин хөлс, оюутнуудын замын зардлын өглөг байна.

Үзүүлэлт	2015 он	2016 он
Цалингийн өглөг	116,582,733.89	140,369,256.36
Дансны өглөг	294,726,115.89	41,112,481.39
Бусад өглөг	112,635,814.93	447,000.00
Замын зардлын үлдэгдэл	7,268,000.00	7,268,000.00
НДШ-ийн өглөг	422,227.65	76,294.68
Дүн	531,634,892.36	189,273,032.43

Урьдчилж орсон орлого

Урьдчилж орсон орлого нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

Үзүүлэлт	2015 он	2016 он
Бакалаврын сургалт	5,425,170,666.98	4,551,773,085.56
Магистрын сургалт	468,877,425.03	357,365,688.20
Лицей сургуулийн	1,004,000.00	7,192,000.00
Оюутны байрны	25,141,333.00	19,809,400.00
Хөрөнгийн орлого		200,000,000.00
Дүн	5,920,193,425.01	5,136,140,173.76

Нийт орлого

Үзүүлэлт	2015 он	2016 он
Урсгал зардлын санхүүжилт	987,006,878.62	1,079,256,296.94
Хөрөнгө оруулалтын санхүүжилт	1,329,077,645.90	789,540,297.85
Орон нутгийн төсвөөс	144,729,324.00	228,149,636.00
Бусад төсөвт байгууллагаас		1,739,316,160.00
Бусад тусгай зориулалтын сангаас	1,228,286,700.00	1,172,681,100.00
Бусад байгууллагаас	358,372,654.10	545,009,682.31
Үндсэн үйл ажиллагааны орлого	31,488,128,662.95	36,320,693,758.92
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	5,718,634,096.25	5,322,457,235.05
Торгууль төлбөрийн орлого	272,247,939.53	398,906,355.19
Нийт орлогын дүн	41,526,483,901.35	47,596,010,522.26

Нийт зардал

Үзүүлэлт	2015 он	2016 он
Цалин	21,409,208,561.58	23,082,082,306.66
Нийгмийн даатгалын шимтгэл	2,349,884,684.10	2,553,628,304.30
Гэрэл цахилгааны зардал	471,222,662.92	549,808,403.00
Түлш, халаалтын зардал	367,790,294.70	386,467,372.33
Цэвэр, бохир усны зардал	147,993,921.00	142,980,521.56
Эмийн зардал	3,912,079.98	3,045,066.77
Бичиг хэргийн материал	107,182,501.89	80,211,341.59
Тээвэр, шатахууны зардал	29,516,824.17	29,800,409.72
Шуудан холбооны зардал	231,142,482.56	224,736,239.43
Дотоод албан томилолтын зардал	23,396,716.76	15,469,393.17
Гадаад албан томилолтын зардал	57,350,283.65	54,332,056.00
Ном, хэвлэлийн зардал	34,309,456.52	67,949,268.57
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,211,217,299.70	1,303,545,122.86
Сургалт семинарын зардал	419,273,338.47	626,547,371.10
Эрдэм шинжилгээний ажлын зардал	2,606,942,484.82	3,292,698,777.90
Жижиг эд хогшил худалдан авах зардал	315,965,091.58	313,314,068.45
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	12,807,614.61	2,945,851.88
Төлбөр, хураамж, жижиг татварууд	266,425,821.35	112,653,699.34
Харуул хамгаалалтын зардал	300,828,000.00	299,175,900.00
Банкны үйлчилгээний хураамж	13,783,923.59	6,711,169.28
Урсгал засварын зардал	798,614,200.76	777,306,865.21
Биеийн тамирын уралдаан тэмцээний зардал	64,875,360.00	92,604,864.95
Гадаад зочины зардал	119,743,854.05	198,305,429.83
Бусад зардал	182,519,972.06	327,042,823.91
Элэгдлийн зардал	2,793,405,033.46	2,886,229,543.33
Хөтөлбөр арга хэмжээний зардал	207,237,385.72	291,301,808.21
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	286,015,517.60	354,637,792.28
Бусад зардал	312,941,324.26	99,678,984.88
Дүн	35,145,506,691.86	38,175,210,756.51

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УРСГАЛ ЗАРДЛЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багцад багтах Монгол улсын их сургуулийн 2016 оны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл дараах байдалтай байна.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	21,238,576,742.06
--	--------------------------

Төсвийн санхүүжилт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал зардлын санхүүжилт	4,359,672,440.00	4,906,104,693.85	546,432,253.85	112.53
Үндсэн үйл ажиллагааны орлого	35,938,147,350.00	35,057,882,928.74	(880,264,421.26)	97.55
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	5,524,946,740.00	7,155,053,302.53	1,630,106,562.53	129.50
Нийт орлогын дүн	45,822,766,530.00	47,119,040,925.12	1,296,274,395.12	102.83

Зардлын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	24,949,819,330.00	23,012,404,309.01	(1,937,415,021.0)	92.23
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,744,946,620.00	2,602,195,731.65	(142,750,888.4)	94.80
Бичиг хэрэг	56,476,500.00	37,537,214.00	(18,939,286.0)	66.47
Гэрэл цахилгаан	476,379,500.00	549,808,403.00	73,428,903.0	115.41
Түлш халаалт	403,928,870.00	395,651,702.54	(8,277,167.5)	97.95
Цэвэр, бохир ус	169,324,470.00	141,692,466.35	(27,632,003.7)	83.68
Тээвэр (шатахуун)	51,928,480.00	26,349,005.00	(25,579,475.0)	50.74
Шуудан, холбооны зардал	265,411,770.00	224,459,893.20	(40,951,876.8)	84.57
Албан томилолт	59,257,980.00	17,627,578.40	(41,630,401.6)	29.75
Урсгал засвар	856,884,140.00	785,630,395.00	(71,253,745.0)	91.68
Харуул хамгаалалтын зардал	300,828,000.00	299,175,900.00	(1,652,100.0)	99.45
Төлбөр, хураамж, жижиг татварууд	321,014,040.00	237,573,495.13	(83,440,544.9)	74.01
Ном хэвлүүлэх зардал	80,080,000.00	41,995,826.00	(38,084,174.0)	52.44
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,124,094,360.00	1,199,835,618.17	(924,258,741.8)	56.49
Эрдэм шинжилгээний ажлын зардал	2,991,207,800.00	3,768,159,459.92	776,951,659.9	125.97
Гадаад арга хэмжээний зардал	484,444,240.00	257,171,914.09	(227,272,325.9)	53.09
Шагналын зардал	59,434,300.00	49,808,570.00	(9,625,730.0)	83.80
Оюутны үйлчилгээний зардал	647,200,540.00	473,894,178.00	(173,306,362.0)	73.22
Салбарын төвлөрсөн арга хэмжээний зардал	301,596,000.00	282,325,431.00	(19,270,569.0)	93.61
Сургалт семинарын зардал	737,300,410.00	631,682,796.40	(105,617,613.6)	85.68
Замын зардал	141,742,600.00	100,936,600.00	(40,806,000.0)	71.21
Тогтмол хэвлэлийн зардал	51,830,020.00	25,434,554.00	(26,395,466.0)	28.39
Биеийн тамирын уралдаан тэмцээний зардал	89,579,900.00	86,813,824.00	(2,766,076.0)	19.27

Аж ахуйн зардал	450,426,690.00	439,277,806.17	(11,148,883.8)	98.79
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	444,664,440.00	293,348,624.32	(151,315,815.7)	65.97
Төсөвт зардлын дүн	39,259,801,000.00	35,980,791,295.35	(3,279,009,704.7)	91.65
Үндсэн хөрөнгө бэлтгэх зардал	15,696,319,770.00	10,703,314,176.89	(4,993,005,593.11)	68.19
Мөнгөн хөрөнгийн нийт зарцуулалт	54,956,120,770.00	46,684,105,472.24	(8,272,015,297.76)	84.95
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	21,673,512,194.94			